

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ БОЛОН АУДИТ, БУСАД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

2024 ОНЫ ХУДАЛДАН АВАЛТ: 2024 оны байдлаарх компанийн хэмжээнд худалдан авах төлөвлөгөөнд нийт 94 нэр төрлийн ажлыг төлөвлөж, худалдан авах арга хэмжээ зохион байгуулсан байна. Гүйцэтгэлээр гэрээ дүгнэж акт үйлдсэн буюу 100%-ийн гүйцэтгэлтэй 46 нэр төрлийн бараа үйлчилгээний гэрээг дүгнэж акт баталгаажуусан байна. Гэрээ байгуулагдсан ажил хийгдэж байгаа, гэрээг дүгнэх хугацаа болоогүй 48 нэр төрлийн бараа үйлчилгээ байна.

Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой цаашид анхаарах асуудал:

1. МЭЗ ХХК-тай хийсэн гэрээний хугацааг анхаарах /Зуух №2 Их засвар/
2. Дээд тив ХХК-тай хийсэн гэрээ /Агаар хөргөгч нийлүүлэх гэрээ/
3. Ай жэй эй эйч аудит ХХК-тай хийсэн гэрээ / Зөвлөх үйлчилгээний гэрээ НБББББ/
4. Атен ХХК-тай хийсэн гэрээ / Хөрөнгийн үнэлгээ /

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Захиргаанаас гаргасан тушаал, ТУЗ-ийн шийдвэрүүд нь хууль эрх зүйн баримт бичгүүдэд нийцэж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь хангалттай түвшинд байна.

2. Тайлангийн хугацаанд: Цахилгаан эрчим хүчний орлого 23,890.7 сая.төг, Дулааны эрчим хүчний орлого 2,079.4 сая.төг, Үйл ажиллагааны бус орлого 229.9 сая.төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт орлогын дүн 26,200.0 сая.төг байна. Нийт борлуулалтын орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 259.1 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 89 хувийг ЦЭХ-ний, 11 хувийг ДЭХ-ний орлого эзэлж байна. 2024 оны 03 дугаар улирлын байдлаар үйл ажиллагааны бус орлогоор 230.5 сая төг олохоор төлөвлөн 229.9 сая төгрөг олж төлөвлөгөөг 74.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

3. Тайлангийн хугацаанд 28,727.7 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 27,463.7 сая төгрөгийн зардал гарган, төлөвлөгөөнөөс 1,263.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Нийт зардлын 40 хувийг түлшний зардал, 33 хувийг цалингийн зардал, 12 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 10 хувийг бусад тогтмол зардал эзэлсэн байна.

4. 2024 оны 09 сарын байдлаар нийт 12,551.57 сая төгрөгийн бараа материалын орлого бүртгэж, 11,458.7 сая төгрөгийн бараа материалыг үйлдвэрлэлд зарцуулж 2,799.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа

материалын үлдэгдэл оны эхнээс 1,092.8 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын өссөн шалтгаан нь нүүрс үлдэгдэл байна.

5. Шалгалтын явцад 2024 оны 1-р сараас 9 сар хүртэлх хугацааны кассын үйл ажиллагааг шалгаж, илэрсэн 8 зөрчилийг хугацаат үүрэг өгч арилгуулсан. Мөн гэрээний бүрдэл дутуу зэргийг сануулж, гэрээний дугаарлалтыг нягтлах, хугацаандаа гэрээг дүгнэх зэргийг цаашид анхаарч талаар зөвлөмж хүргүүлж ажилласан байна.